

ХИЛИЙН АЛБАНЫ УДИРДЛАГА, СТРАТЕГИ

ХИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН БОЛОН ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Ц.Ганболд

ДХИС, Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор(Ph.D), профессор, хурандаа

Б.Алтанхүү

Стратеги Судалгааны хүрээлэнгийн ахлах шинжээч, хурандаа

Агуулга: Менежмент, хилийн менежментийн тухай ойлголт, томъёолол, агуулга, ач холбогдлыг хүргэх болон хилийн менежмент, Монгол Улс дахь хилийн менежментийн хөгжлийн байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, үүний үндсэн дээр шийдвэрлэх шийдлийг сонгоход санал, зөвлөмж хүргэх зорилготой.

Түлхүүр үгс: Менежмент, хилийн /цогц, цогцолбор, хамтарсан, зохицуулалттай/ менежмент, шилжилт хөдөлгөөний бодлого боловсруулах олон улсын төв

Abstract: The goal is to assess the current state of border management in Mongolia, identify challenges, and propose solutions. This involves analyzing management practices and border control measures to improve efficiency and security. Recommendations will be based on the findings to enhance border management in Mongolia.

Key words: Management, border management /complex, joint, coordinated/, The International Center for Migration Policy Development (ICMPD)

Оршил. Менежмент гэсэн ойлголт нь удирдах, жолоодох, манлайлах (manage) гэсэн утга бүхий англи үгнээс гаралтай. Менежментийг үйл ажиллагаа болох талаас нь хялбаршуулан авч үзвэл энэ нь хүмүүсээр ашигтай үйл бүтээлгэх, ажил хэрэг өрнүүлэх урлаг юм.

Ер нь менежментийн уг утга нь байгууллагын зорилгыг тодорхойлж,

түүнд хүрэх арга замыг төлөвлөх, ажиллах хүч, санхүү, материалын бүх нөөцийг ашиглалтыг оновчтой зохион байгуулж, хүмүүсээ шилж сонгох, манлайлах, ажиллах, үйлдвэрлэлийн явц, эцсийн үр дүнд хяналт шалгалт хийх нэгдмэл үйл ажиллагаа юм.

Менежментийн онол, түүний хөгжил нь удирдлагад шууд хамаарагддаг математик, сэтгэл судлал

ба социологи, хүн судлал зэрэг шинжлэх ухааны хөгжлийн зүй ёсны үр дүн.

Менежмент гэдэг үг орчуулгагүйгээр хэвшин идээшиж, хаана ч хэн ч ярьж хэрэглэдэг болсон нь тухайн шинжлэх ухааны ач холбогдлыг өргөж байгаа хэрэг, бас манай амьдралд түргэн нэвтэрч байгааг харуулж байна.

Менежментийн шинжлэх ухаан америк болон өрнөдийн орнуудад хөгжлийн нарийн түүхийг туулж улам нарийсан салбарлан хөгжиж ирсэн. Аливаа шинжлэх ухаан үүсэж хөгжлийн тодорхой үе шатыг дамждагийн адил менежментийн шинжлэх ухаан өөрийн үүссэн цаг хугацаа, үзэл баримтлал, нөхцөл шалтгаан, үр дагавар, орон зайтай юм.

Нэг нь ажиллаж, нөгөөх нь захирч ажлаа хийлгүүлдэг ийм харилцаа бий болсноор удирдлагын шинжлэх ухааны үр хөврөл үүсэж бий болжээ.

Иймээс удирдлагын янз бүрийн хэлбэр, арга барил орон оронд олон зуун жилийн турш хурж хуримтлагдсаар «Менежмент» хэмээх удирдлагыг судалдаг ухаан бие даасан шинжлэх ухаан болтлоо хөгжсөн байна.

Менежментийн шинжлэх ухааныг хамгийн товчоор тодорхойлон хэлбэл, байгууллагыг шинжлэх ухааны үндэслэл бүхий системтэй удирдах онол гэж болох юм.

Удирдагч хүнд байгууллагаа авч явах ур ухаан, урлагийг эзэмшүүлдэг ухаан гэж бас болно¹.

«Манлайллын онол». Удирдлагын манлайллын онол, контингенсийн онол нь хил хамгаалалтын системийн зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой².

1648 оны Вестфалын гэрээгээр Бүрэн эрхт “үндэстэн улс” олон улсад анх хүлээн зөвшөөрөгдөж, газар нутаг, хил хязгаартаа бүрэн хяналт тогтоох болсноос эхлэн улс орнууд улсын хилээ хамгаалах төрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тодорхой бүтэц, механизм ашиглаж ирсэн. Тухайн үеийн улсын “хил хязгаар нутаг”-ийн ойлголт өнөө үед “улсын хил”, улам бүр нарийсаж “улсын хилийн шугам” болж илүү тодорхой болсноор улсын хилээ удирдах (менежмент хийх) ажиллагаа нь ч боловсронгуй болж, хилийн менежментийн байгууллагууд нь ч улам бүр төрөлжин хөгжиж ирсэн байна.

“Хилийн менежмент”-ийн үйл ажиллагаанд, нэг талаас, тухайн улсын аюулгүй байдал, хилийн халдашгүй дархан байдлыг хангах, нөгөө талаас, улсын хилээр зорчигч, бараа, бүтээгдэхүүнийг илүү шуурхай нэвтрүүлэх гэсэн хоёр чухал зорилгыг нэгэн зэрэг, тэнцвэртэй, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байдаг.

“Хилийн менежмент”-ийг ямар өнцгөөс харж буй нь тухайн улс орон, байгууллагын тэргүүлэх чиглэлийн зорилгоос хамаардаг. Тухайлбал, НҮБ, Интерпол зэрэг байгууллагын хувьд

¹ Цэнджав, До., Дорж, Т. Хэвлэл мэдээллийн менежмент. -Уб., 2004.

² Мөн тэнд.

үндэстэн дамнасан гэмт хэргээс сэргийлэх зорилгоор аюулгүй байдлын үүднээс “Хилийн менежмент”-ийг сайжруулах асуудлыг хөнддөг бол Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Дэлхийн Банк, Дэлхийн гаалийн байгууллага нь улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг үр дүнтэй, шуурхай байлгах асуудалд гол анхаарлаа хандуулж байна. Ямар ч тохиолдолд улсын хил хамгаалах болон гаалийн байгууллага нь үр дүнтэй “Хилийн менежмент”-ийг хэрэгжүүлэх тулгуур байгууллага болох бөгөөд “Хилийн менежмент”-ийн агуулга нь “харилцаа, хамтын ажиллагаа”, “цогцоор эсхүл нэгдсэн байдлаар хандах”, “Засгийн газрын хэмжээнд хандах” зэрэг асуудлыг агуулах болж байна.

Хилийн менежмент, хөгжлийн чиг хандлага

Хилийн менежментийн зорилго нь улсын хилээр нэвтрэх хууль ёсны хөдөлгөөн чөлөөтэй, шуурхай, хил үүнд нээлттэй байх ёстой боловч үндэсний аюулгүй байдлын үүднээс улсын хилээр хууль бус аливаа хөдөлгөөн нэвтрүүлэхгүй байх аюулгүй байдлын асуудал болно.

Хилийн менежмент

Хилийн менежмент гэж юу вэ? Хилийн менежментийн асуудлыг олон улсад болон дотоодод олон янзаар ойлгож байна. Улсын хилтэй холбоотой чиг үүрэг бүхий олон улсын болон аливаа улсын байгууллагууд өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд

Хилийн менежментийг онолын хувьд судлаачид хоёр өнцгөөс харж, хоёр чиглэлээр тайлбарладаг байна. Нэг хэсэг нь улсын хил холбогч байж үзээд нээлттэй, улс оронд ашигтай, улс төр, эдийн засаг эрх зүйн аргаар зохицуулагдаж, төрийн болон бусад байгууллага иргэд хилийн харилцаанд өргөн агуулгаар оролцох ёстой гэж үздэг. Харин нөгөө хэсэг нь хил тусгаарлагч байж, хаалттай, аюулгүй байх ёстой, хилийн аюулгүй байдлыг цэргийн болон аюулгүй байдлын бусад аргаар хангаж, үүнд үндэсний аюулгүй байдлын чиг үүрэг бүхий байгууллагуудын үүрэг роль өндөр хэмжээнд байх шаардлагатай гэж үздэг. Практикт энэ хоёр хандлагыг ямар нэг хэмжээгээр агуулсан хилийн менежмент оршин байх бөгөөд аль чиглэлд илүү хазайснаас хамаарч тухайн улсын хилийн бодлого, менежмент тодорхойлогдож байдаг байна.

Зураг 1



хилийн менежмент гэдэг ойлголтыг ярьдаг. Тухайлбал, ЕАБХАБ (OSCE)-ын Сайд нарын зөвлөлийн 2005 оны MC (13) шийдвэрээр Хилийн аюулгүй байдал, менежментийн үзэл баримтлал (Border Security and Management Concept)-ыг баталсан билээ. Энэхүү үзэл баримтлалын хүрээнд хилийн

аюулгүй байдалд нэг байгууллага болон нэг нэгжийн зорилго, эрх ашиг биш улс орны болон олон улсын хамтын нийгэмлэгийн эрх ашиг тэргүүн эгнээнд байх ёстой учраас хилийн аюулгүй байдлыг хангахад хамтын ажиллагаа ихээхэн чухал гэж үзэж байна. Энэхүү хамтын ажиллагааг хилийн асуудлаар үүрэг хүлээсэн

байгууллага доторх, тэдгээр байгууллага хоорондын, улс хоорондын хамтын ажиллагаа (Зураг 2) гэсэн хүрээнд авч үзэж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр түвшинд хамтын ажиллагаа байгаа үед хилийн менежмент үр дүнтэй байж, хамтын ажиллагаа доголдсон үед хилийн менежментийн үр дүн доголддог байна.

Зураг 2



Эндээс харахад хилийн нэгдсэн менежмент буюу хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоо гэдэг нь хилийн асуудлаарх хамтын ажиллагааны асуудал болж харагдаж байна. Хилийн нэгдсэн менежментийг зарим тохиолдолд *зохицуулалттай менежмент* гэдэг ойлголтын хүрээнд дэлхийн олон улсад хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Европын холбооны улсуудын хувьд хилийн нэгдсэн менежмент гэж байхад холбооны түвшинд биш харилцаатай орнуудын хувьд хилийн зохицуулалттай менежментийг хэрэгжүүлж байна. Европын холбоонд Фронтекс (Frontex-European agency for operational cooperation at the external borders of the

European Union member states) - Европын хилийн болон эргийн хамгаалалтын агентлаг энэ менежментийг хэрэгжүүлэх бөгөөд хил дамнасан шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, гэмт хэрэг, зөрчил, олон улсын эдийн засаг улам бүр тэлж буй үед улс орны болон олон улсын түвшинд хилийн асуудал хариуцсан байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, уялдуулах шаардлага зайлшгүй бий болж байна гэж үзэж байна.

Хилийн нэгдсэн менежментийг “Нээлттэй боловч найдвартай, хяналттай, аюулгүй хилтэй байх зорилтыг хангахын тулд үр дүнтэй, ашигтай, зохицуулалттай хилийн

менежментийг бий болгох хилийн аюулгүй байдал, худалдааны асуудал хариуцсан бүхий л холбогдох эрх бүхий байгууллага, агентлагуудын улс орны болон олон улсын хэмжээний зохицуулалт, хамтын ажиллагааны замаар үр дүнтэй, зохицуулалт сайтай хилийн менежмент байгуулах зарчим юм” гэж тодорхойлсон байдаг.

Энэ нэр томьёо нь янз бүрийн оролцогч талуудын ашиг сонирхол, чиг үүргийн тэнцвэрийг хадгалан /хууль дүрэм мөрдөн сахих шаардлагад нийцүүлэн/ худалдаа болон зорчигчдын урсгалыг илүү үр дүнтэй удирдан зохицуулах зорилгоор хилийн хяналтын дотоодын болон олон улсын байгууллагууд ажлаа уялдуулан зохицуулах арга хэмжээг илэрхийлдэг.

“Хилийн зохицуулалттай менежмент” гэдэг нэр томьёонд:

- Мэдээлэл солилцох;
- Нэгдсэн барилга байгууламжтай байх;
- Байгууллагууд хоорондоо нягт хамтран ажиллах;
- Нэг нь нөгөөдөө захиргааны эрх мэдлээ шилжүүлэх;
- Ажилтнуудынхаа чиг үүргийг дамнуулж солих зэргийг хамруулж ойлгодог байна.

Мэргэжлийн хэллэгт хилийн менежментийн үзэл баримтлал гэсэн томьёог “Нээлттэй боловч аюулгүй хил” утгатайгаар хэрэглэх нь түгээмэл хэдий ч Хилийн зохицуулалттай менежмент (Coordinated Border Management, CBM), Хилийн орчин үеийн менежмент (Modern Border Management, MBM) зэрэг томьёог илүүтэй ашиглаж хэрэглэх болсон.

“Цогц” гэдэг үг нь хоёр буюу хэд хэдэн агентлагийг нийлүүлэх гэсэн утгатай бөгөөд энэ нь зарим улс /Тухайлбал, Хил хамгаалалт, гаалийн байгууллага нь хамт нэг удирдлагад ажилладаг АНУ/-ын нөхцөлд тохирч байсан бол өөр бусад олон орны нөхцөлд тохирохгүй байсан юм.

Хилийн /цогц, цогцолбор, хамтарсан/ менежмент гэсэн нэр томьёог дээрх ойлголтыг зарим судлаачид хамгаалж байгаач “Хилийн зохицуулалттай менежмент” нэр томьёог ашиглахыг илүүд үзэж байгаа. Гэхдээ үзэл баримтлалын томьёолол нь чухал бус боловч хилийн менежментийн бүх үзэл баримтлалд “Зохицуулалт”, “Хамтын ажиллагаа” гэсэн хоёр үндсэн агуулга нь хадгалагдаж байдаг онцлогтой.

Хилийн цогцолбор менежментийн гол элементүүд нь хууль, эрх зүйн ба зохицуулалтын тогтолцоо, байгууллагын тогтолцоо, менежментийн холбогдол бүхий тухайлбал, хилийн шалгалт, хяналт, худалдааг дэмжих, шилжин суурьших хөдөлгөөн, байгууллагын дотоодын, хоорондын болон олон улсын хамтын ажиллагаа зэрэг үйл ажиллагааны болон техникийн асуудлууд хамрагддаг. Түүнчлэн эрсдэлийн дүн шинжилгээ, гэмт хэргийг тагнах болон мөрдөн байцаах, хамтарсан арга хэмжээ, хүний нөөц болон сургалт, авлигаас сэргийлэх, дэд бүтэц, техник төхөөрөмж, мэдээллийн технологийн системүүд зэрэг асуудлуудыг харгалзан үздэг.

Хилийн зохицуулалттай менежментийн гол үзэл санаа нь

зорчигч, ачаа барааны эргэлтийг хөгжүүлэхийн зэрэгцээ хил дамнасан гэмт хэрэг, улсын аюулгүй байдал, хэв журам, эдийн засаг болон нийгмийн эрүүл мэндэд аюул учруулахаас хамгаалахад оршдог. Эдгээр зорилтуудыг биелүүлэхийн тулд

хилийн менежментэд хамаарал бүхий бүх байгууллагуудын хамтран ажиллах, мэдээлэл солилцох, ажлын бүх талын зохицуулалт хийхийг шаарддаг.

Зарим олон улсын байгууллагуудын Хилийн менежментийн ойлголт ялгаатай байна.

Хүснэгт 1

№	Олон улсын байгууллагын нэр, хилийн менежмент хариуцсан нэгж	Хилийн менежментийн зорилго, ойлголт
1	OSCE Хилийн менежмент Хилийн менежментийн штабын коллеж, Душанбе	Хууль ёсны аялал, худалдааг хөнгөвчлөх, хүний эрхийг хамгаалах, хүн хоорондын харилцааг дэмжих замаар Хилийн менежмент, аюулгүй байдлыг дээшлүүлэх зорилготой.
2	НҮБ-ын Хар тамхи, гэмт хэргийн алба Хилийн менежмент	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд хамгийн чухал зүйл бол үр дүнтэй хилийн хяналттай байх явдал бөгөөд энэ зорилгоор бүс нутгийн интеграци, хилийн менежментийг сайжруулах зорилготой.
3	Европын Холбооны Евро-Комиссын Шилжилт хөдөлгөөн Нэгдсэн Хилийн менежмент (FRONTEX)	Хилийн хяналт, эрсдэлийн үнэлгээ, мэдээлэл солилцоо, агентлаг хоорондын хамтын ажиллагаа, орчин үеийн дэвшилтэт технологийн ашиглалт зэргийг багтаасан Европын Нэгдсэн Хилийн менежментийг хэрэгжүүлэх.
4	ИНТЕРПОЛ Хилийн менежмент	Хүн, бараа, бүтээгдэхүүн агаар, газар, усан хилээр нэвтрэх нь маш хялбар болсон энэ үед улсын хилийг хууль бусаар ашиглах явдлаас сэргийлэх зорилготой. Хилийн аюулгүй байдлын хангах нь үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх нь чухал чиг үүрэг.
5	ICMPD Олон улсын шилжилт хөдөлгөөний бодлого хөгжүүлэлтийн төв	Хилийн менежмент гэдэг зөвхөн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа биш харин эдийн засаг, нийгмийн

	Хилийн менежмент, Аюулгүй байдал	хөгжил, худалдаа, харилцаа, хилийн орон зайн ард түмний асуудлыг багтаасан цогц ойлголт. Агентлаг дотор, агентлаг хооронд, улс хоорондын гэсэн гурван түвшний Нэгдсэн Хилийн менежмент гэдэг загварыг суурь болгоно.
6	Дэлхийн банк Хамтын ажиллагаатай хилийн менежмент	Хилийн менежментийг сайжруулах замаар хил дамнасан хууль ёсны худалдааг шуурхай, хялбар болгох.
7	Дэлхийн Гаалийн байгууллага Зохицуулалттай Хилийн менежмент	Худалдаа, зорчих урсгалыг илүү үр дүнтэй удирдах асуудлыг хууль дүрмийн шаардлагатай тэнцвэржүүлэх зорилготой, гадаадын болон дотоодын хилийн хяналтын байгууллагуудын зохицуулалттай хандлага.
8	Дэлхийн Худалдааны байгууллага Хилийн албаны зохицуулалт	Гадаадад болон дотоодод хилийн агентлагуудын үр дүнтэй харилцаа, хамтын ажиллагаа

Хэдийгээр Монгол Улсын хувьд хилийн менежментээс илүү хил хамгаалалт гэсэн нэр томъёог нийтлэг ашиглаж, улсын хил хамгаалалтын асуудлыг хөнддөг боловч сүүлийн үед хилийн аюулгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал гэсэн нэр томъёо төрийн бодлогын болон эрх зүйн баримт бичгүүдэд тусгалаа олж, онол, практикт ашиглагдах болсон. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байх тухай зарчим агуулагддаг³ бол 2002 онд УИХ-ын 20 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Төрөөс хилийн талаар

баримтлах бодлого” баримт бичигт Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал болон хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал гэсэн нэр томъёонуудын агуулгыг тодорхой тусгасан.

Хилийн халдашгүй дархан байдал нь улсын хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөхгүй байх, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ зөрчигдөхгүй байх явдлаар хангагдах бол Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдох юм. 2016 онд

³Монгол Улсын Үндсэн хууль, 4-р зүйл, 1992 он

батлагдсан Хилийн тухай хуульд Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байхаар тодорхойлсон.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого маань өөрөө Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг бол Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын нэг хэсэг болно. Харин улсын хил хамгаалалт нь хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг юм. Эндээс харахад хилийн аюулгүй байдлыг хангах асуудал нь улсын хил хамгаалалтаас агуулгын хувьд өргөн бөгөөд зөвхөн хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй нь тодорхой байна.

Тэгвэл “Хилийн менежмент”-ийг Монгол Улсын эрх ашгийн үүднээс хэрхэн тодорхойлох вэ?

Улсын хил хамгаалалт нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл

ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа байдаг. Тэгвэл бол “Хилийн менежмент” нь улс орны нийгэм, эдийн засаг, аюулгүй байдлын нөхцөл байдалд нийцүүлэн хилийн асуудлыг удирдах, зохион байгуулах өргөн хүрээтэй, төрийн дээд түвшний асуудал болж байна.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 5.3-д “Хилийн аюулгүй байдал нь ...төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулж байгаа улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, экологи, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана”, 5.4-д “Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Монгол Улсын Засгийн газар хариуцна” гэж заасан.

Мөн үүнтэй яг ижил агуулгатай заалт Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын 1.9-д “улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна”;

3.1-д Хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж удирдах, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагын

санхүүжилт, материал техникийн хангамжийн норм хэмжээг тогтоох, хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу хилийн асуудлаар олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах зэрэг асуудлыг Засгийн газар хариуцан хэрэгжүүлэх” гэж тус тус заасан нь өнөөгийн манай нөхцөлд “Хилийн менежмент”, түүний хүрээ, хэрэгжүүлэх субъектийн эрх зүйн үндэс гэж үзэж болохоор байна.

Өөрөөр хэлбэл, Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага байж, хуулийн биелэлтийг зохион байгуулж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах төрийн менежментийг хэрэгжүүлэгч дээд

субъектийн хувьд Хилийн менежментийг улс орны хэмжээнд хэрэгжүүлнэ. Засгийн газраас хилийн асуудлаар явуулж буй бүхий л үйл ажиллагааг “Хилийн менежмент” гэж үзэж болохоор байна. Иймд “Хилийн менежмент” гэдэг нь төрөөс хилийн талаар явуулж буй цогц үйл ажиллагаа учраас энд Хил хамгаалах байгууллага төдийгүй Гааль, эрүүл ахуй, хорио цээр, Гадаадын иргэн түүнчлэн ГХЯ, БОАЖЯ, ЗХЖШ, ТЕГ, ЦЕГ гэх мэт хилийн талаар тодорхой хүлээсэн үүрэгтэй төрийн бусад олон байгууллагын үйл ажиллагааны нэгдлийг хилийн менежмент гэж ойлгох ёстой болж байна

Зураг 3



Хилийн менежментийн хөгжлийн чиг хандлага

Орчин үеийн хилийн менежментийн шинэчлэл нь уламжлалт шинэчлэлээсээ ихээхэн өөр, нэгдсэн, цогц, Засгийн газрын хэмжээний

Түүнчлэн орчин үеийн хилийн менежментийн шинэ парадигм хэрэгтэй

хандлага байх ёстой гэж үзэж байна. Үүнд нэгдсэн хилийн менежментийн асуудал яригдаж байгаа үед хилийн асуудлаар үүрэг хүлээсэн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа чухал болж байна.

болж байна. Тухайлбал, Зохицуулалттай хилийн менежмент,

Хилийн хяналтын нэг зогсоол, нэг цонхны, Нэгдсэн, Уялдаатай, Хамтарсан, Зохицуулалттай хилийн менежмент гэсэн ойлголт, нэр томьёо гарч ирж байна. Хилийн менежментийг явуулахад дэс дараатай хандах (Structured approach to border management), хүний нөөцийг илүү үр дурдаж болно.

бүтээмжтэй ашиглах (More efficient usage of human resource), эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх (Risk management), оролцогч талууд нь өөр өөрийн зорилгоо биелүүлэх боломжтой байх (Stakeholders benefits) зэргийг эхний ээлжид



Зураг 4.

Нөгөө талаас шинэлэг хилийн менежментийг хэрэгжүүлэхэд юуны түрүүнд улс орны хэмжээний манлайлал, стратегийн шинэ алсын хараа, улс төрийн хүчтэй хүсэл эрмэлзэл зайлшгүй шаардлагатай болж байна.

Мөн үндэсний хэмжээний хилийн менежментийн загварыг тухайлан гаргах нь чухал асуудал болж байгаа юм. Үүнд гурван гол зүйлд анхаарлаа хандуулах нь зайлшгүй болно. Тухайлбал, **нэгдүгээрт**, бодлого боловсруулагчдын зүгээс хилийн менежментийн уламжлалт элементүүдэд зарцуулах нөөцийг шинэ тутам, тухайлбал, IT-д суурилсан технологид хэрхэн тэнцвэртэйгээр ашиглах, шинэ технологид зориулахдаа түүний сул талыг хэрхэн бууруулах

асуудал, **хоёрдугаарт**, хилийн менежментийг хөгжүүлэх бүхий л арга хэрэгсэл нь хуулийн хүрээнд байх ёстой болно. Ялангуяа энэ нь хувь хүний давтагдашгүй өгөгдлийг авах, тараах, ашиглах зэрэгт илүү хамааралтай юм. **Гуравдугаарт**, хувийн хэвшлийн хөрөнгө, ноу-хау нь хилийн менежментийн технологийг хөгжүүлэхэд зайлшгүй чухал гэдгийг тооцох зэрэг асуудал чухлаар тавигдаж байна.

Австралийн PWC байгууллагын тооцсоноор, Хилийн менежментийн хөгжилтөд “Санаачилгатай, уян хатан хандлага” - ийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь хилийн менежментийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлно гэж үзэж байна.



“Монгол Улсын хилийн менежментийн тайлан”-г Монгол Улсын хилийн менежментийн тогтолцооны үндсэн үзүүлэлтүүд болон хэрэгцээг тодорхойлох, хилийн менежментийг ирээдүйн хөгжил, шинэчлэлийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх зорилгоор 2013 онд Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүсэлтээр Австри Улсын Вена хот дахь Шилжилт хөдөлгөөний бодлого боловсруулах олон улсын төв (ШХББОУТ, ICMPD) хийсэн байдаг.

Монгол Улсын хилийн аюулгүй байдал, хилийн менежменттэй ямарваа нэгэн байдлаар холбогдох ГИХА, ГЕГ, ХХЕГ, ХСИС, ХЗДХЯ, ЦЕГ, Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх хэлтэс, АТГ, Шинэчлэл, Төр-хувийн хэвшлийн түншлэлийн газарт судалгаа явуулсан байдаг.

Гол дүгнэлт, үнэлгээ нь:

Монгол Улсын хилийн менежмент нь үндсэндээ хилийн орчин

үеийн менежментийн зарчимд тулгуурласан байна.

Хилийн байгууллагуудын хамтын ажиллагааны түвшин, бодлогын зохицуулалтын уялдаа, байгууллагуудын чадавхыг хөгжүүлэх, мэдээллийн технологийн ашиглалт, эрсдэлийн менежмент болон дүн шинжилгээний ажил харьцангуй сул байгаа нь үнэлгээний явцад тогтоогдов.

Ялангуяа хилийн шалгалт, хяналтын үүргийг гүйцэтгэх, эрсдэлийн үр дүнтэй шинжилгээ хийх, байгууллага хоорондын хамтын ажиллагааны асуудал, тухайлбал, үүрэг хариуцлага болон эрх зүйн хуваарилалт хийх, харилцан ажиллагаа ба мэдээлэл солилцоог зохион байгуулах, мэдээллийн нэгдсэн санг ашиглах зэрэг ажиллагаа зохицуулалт ихээхэн сул байна. Түүнчлэн хүний болон санхүүгийн нөөц, дэд бүтэц, шаардлагатай барилга байгууламж, техник хэрэгсэл зэрэг нэн чухал ач холбогдолтой бус боловч

шийдвэрлэвэл зохих асуудлууд байна гэсэн дүгнэлт гаргасан.

Хэдийгээр өнөөгийн тогтолцоо нь зорилтоо хэрэгжүүлж байгаа боловч Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг даган хилийн менежментийг боловсронгуй болгох тулгамдсан шаардлага байна гээд, үүнийг хэрэгжүүлэхдээ хоорондоо уялдаа муутай, олон янзын хэрэгцээ шаардлага, улсын эдийн засаг, улс төрийн нөхцөл, хилийн цогцолбор менежментийн үзэл баримтлалын сонголтыг харгалзана.

Хамгийн гол нь хилийн цогцолбор менежментийг нэвтрүүлэхдээ, хэрэгжүүлэхдээ улс орныхоо дотоодын бодит нөхцөл байдалд нийцүүлэх нь чухал болохыг анхааруулсан.

Хилийн менежментийн тодорхой агентлагийн үйл ажиллагааны ерөнхий үнэлгээг гаргасны дараа эдгээр байгууллагын тодорхойлсон тэргүүлэх чиглэлийг үндэслэн ирээдүйн хөгжлийн зарим зөвлөмжийг оруулсан. Зөвлөмжүүдэд хэрэгжүүлэх бодит арга хэмжээний санал, салбар, үйл ажиллагааг тусгасан.

Аргачлал

Монголд ажиллах хугацаанд үнэлгээний баг нь аргачлалын хүрээнд хууль эрх зүйн тогтолцоо, байгууллагын тогтолцоо, захиргаа удирдлага, үйл ажиллагаа, мэдээллийн менежмент зэрэг таван гол чиглэлээр, шаардлага гарсан тохиолдолд эрсдэлийн дүн шинжилгээ болон холбогдох бусад чиглэлээр үнэлгээ хийв. Хилийн менежментийн талаар хийсэн үнэлгээ, зөвлөмжийг

тайлангийн үндсэн хэсэгт тусгасан ба аргачлалын дагуу хилийн гол агентлагуудын үйл ажиллагаанд анхаарлыг хандуулж, холбогдол бүхий бусад байгууллагуудыг зөвхөн хэрэгцээтэй нөхцөлд хамруулсан болно (бүлэг 9).

Үнэлгээний баг нь Монгол Улсын хилийн менежментийн тулгамдсан болон дунд хугацааны чадавхыг хөгжүүлэх шаардлага, хэрэгцээнд иж бүрэн үнэлгээ хийхийг зорив.

Өнөөгийн бодит байдал, бүтцэд хийсэн үнэлгээ:

А.Зохицуулалтын тогтолцоо

- Хилийн менежмент, худалдааг дэмжих бодлого, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн үнэлгээ;

- Хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцооны мониторинг ба хэрэгжүүлэлт- сорилт болон сул талууд;

- Хилийн менежменттэй холбоотой бодлогыг тодорхойлох үндэсний тэргүүлэх чиглэлүүд, ирээдүйн чиглэлүүд.

В.Байгууллагуудын тогтолцоо

- Хилийн менежменттэй холбогдол бүхий Монголын агентлагуудын үйл ажиллагааны зорилт, үүрэг, хариуцлагын үнэлгээ;

- Хилийн менежменттэй холбогдол бүхий агентлагуудын үйл ажиллагааны дотоод зохицуулалтын механизм, байгууллага хоорондын ажиллагаа, сорилт болон сул талуудын үнэлгээ;

- Өнөөгийн зохицуулалтын механизмуудын үнэлгээ;

- Хилийн менежментийн төвлөрсөн механизмууд (мэдээллийн сан, зохицуулалтын механизм болон хариуцах байгууллагууд, үйл ажиллагааны санал, зөвлөмж, удирдамжууд, тогтсон практик г.м.)-сорилт болон сул талуудын үнэлгээ;

- Хилийн менежменттэй холбогдол бүхий олон улсын түншүүд болон гуравдагч этгээдтэй харилцах зохицуулалтын механизмуудын (олон улсын байгууллагууд, хэрэгжүүлэгч түншүүд) үнэлгээ.

С.Үйл ажиллагаа

Хилийн менежменттэй холбогдол бүхий агентлагуудын үүрэг зорилго, бүтэц, үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ. Үүнд:

- Бүс нутгийн зорчигч тээврийн орох/гарах зөвшөөрөл, агаарын болон газрын боомтуудын ажиллагаа;

- Холбогдох үйл ажиллагааны санал, зөвлөмж, заавар, удирдамжууд-өнөөгийн хэрэгцээ болон шинэчлэх шаардлага;

- Хөдөлгөөний хяналт болон сэрэмжлүүлгийн бүс нутгийн зохицуулалт;

- Хяналтын үүрэг (баримт бичгийн шалгалт, хуурамч баримт бичгийг тогтоох);

- Бүс нутгийн хэмжээнд мөрдөн байцаах болон тагнуулын мэдээлэл цуглуулах, зохицуулах ажиллагаа явуулах;

- Аюулгүй байдлыг хангах үүрэг, тогтолцоо.

Д.Захиргаа, удирдлага

Хүний нөөцийн үнэлгээ:

- Ажилд томилох, ёс суртахуун болон зохион байгуулалтын бүтэц, ажлын хуваарилалт болон ачаалал;

- Ажлын байрны болон менежментийн ур чадварыг дээшлүүлэх сургалт (анхан шатны, шат дараалсан болон тэргүүлэх чиглэлийн);

- Аудит, мөрдөн байцаах ажиллагаа, байгууллага хоорондын ажлын уялдаа;

- Цалин хөлс, ажлын байрны шаардлага, стандарт зэрэг ажлын нөхцөл;

- Үнэт зүйлс болон ажиллагааны хэм хэмжээ;

Е.Мэдээлэл солилцоо ба мэдээллийн технологи

- Хилийн менежментийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий мэдээллийн технологийн орчны үнэлгээ;

- Бүтцийн үнэлгээ;

- Мэдээллийн технологийн аюулгүй байдлын орчин (нэвтрэх хэлбэр, мэдээллийн ашиглалт, хадгалалт, архив, г.м.);

- Мэдээллийн технологийн орчны менежмент болон удирдлага (мэдээллийн сан, лиценз, техникийн дэмжлэг, сангийн зохицуулалт, системийн ажиллагаа);

- Мэдээллийн технологийн шинэчлэл болон шилжүүлэлтийн менежментийн тогтолцоо;

- Мэдээллийн технологийн хяналт, шалгалтын чадавх болон орчин;

- Мэдээллийн технологийн ур чадварын цогц;

Г.Чадавхыг бэхжүүлэх шаардлага

Үнэлгээний баг нь хилийн менежментийн ирээдүйн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хэрэгжүүлэх төслийн бодит нөхцөл байдлыг тогтоохыг зорив.

Дараах асуудлыг харгалзав:

- Холбогдох хууль, журам, бодлого болон үйл ажиллагаа;

- Жилийн тайлан, байгууллагын төлөвлөгөө болон сэдэвчилсэн тайлангууд;

- Боловсон хүчнийг бүрдүүлэх ажиллагаа, тэдний мэргэжлийн чадавх, нөөц болон нөхцөл;

- Мэдээллийн технологийн болон дагалдах хэрэгслийн боломж;

- Зорчигч хөдөлгөөн, паспорт болон иргэншлийн мэдээлэл;

Монгол Улсад хилийн менежментийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд хилийн хамгаалалттай холбогдол бүхий агентлаг тус бүрийн чадавх, оролцоо зохих түвшинд байна. Иймд хэрэгжүүлэх арга хэмжээг шаардлага, холбогдох мэдээлэлд тулгуурлан сонгох хэрэгтэй.

ДГБ, ФРОНТЕХ, АХБ зэрэг олон улсын байгууллагууд, мөн ОХУ, БНХАУ-ын засгийн газартай түншлэл, зохицуулалтын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь тодорхой тохиролцоонд хүрэхэд ач холбогдолтой байж болох юм.

Дараах дүгнэлт, санал, зөвлөмжийг тусгажээ:

1. Улсын хэмжээнд хилийн менежментийн цогцолбор стратегийг боловсруулах шаардлагатай байна. Стратегид хилийн менежменттэй холбогдол бүхий бүх байгууллага

нэгжийг хамруулан, Монгол Улсын засгийн газрын үндсэн зорилтыг тодорхойлох нь зүйтэй. Одоогоор Монгол Улс хилийн менежментийн стратегигүй байгаа нь зорилго, зорилтыг тодорхойлоход хүндрэл учруулж байгаагийн зэрэгцээ холбогдох байгууллагууд нь нэгдсэн ойлголтгүй байна.

2. Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр байх ёстой.

3. Засгийн газрын түвшинд зохицуулалт, хамтын ажиллагааны тогтвортой механизм бүрдүүлэх шаардлагатай байна. Монголын хувьд агентлагуудын үйл ажиллагааг төвлөрүүлэн зохицуулах яам хоорондын хороо байгуулах нь оновчтой шийдэл байж болох талтай. Тус хороо нь стратегийг боловсруулах болон хэрэгжүүлэх ажилд мониторинг хийх үүрэгтэй байвал зохино. Шаардлагатай нөхцөлд ажиллагааг бүсийн, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх зохицуулалтын салбар нэгжүүдийг байгуулж болно.

4. Хууль эрх зүйн үндсэн тогтолцоо бүрдсэн гэж хэлж болно. Хилийн бүх байгууллагууд холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа хэдий ч зарим тохиолдолд хэрэгжүүлэлтийг зохицуулах журам заавар зэрэг хавсралт баримт бичиг боловсруулагдаагүй нийтлэг дутагдал ажиглагдав.

5. Монгол Улс нь өөрийн хилийн шугамыг тогтоож, хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай холбогдох хэлэлцээр байгуулан баталгаажуулсан нь нэн

чухал ач холбогдолтой, хилийн шугамтай холбоотой ямарваа нэгэн шийдэгдээгүй асуудал, маргаангүй болно.

6. Зорчигч, бараа эргэлтэд бэрхшээл учруулж буй гол асуудал байгууллага хоорондын уялдаанд оршиж байна. Ажлын уялдаа муу, эсвэл зөв зохистой хөгжөөгүйн улмаас хилийн ажилтнууд үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байна.

Тухайлбал, Замын-Үүдийн боомтын үйл ажиллагааны журам тодорхой бус, мэргэжлийн чиглэгдсэн ажиллагааны гэхээс өдөр тутмын хэвшмэл үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй байна. Иймд хилийн байгууллага бүр өөрийн үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулах "Үйл ажиллагааны стандартчилсан журам"-ыг боловсруулан хэрэгжүүлэх, шаардлагатай гэж үзэн байгууллага хоорондын журам боловсруулах саналыг дэвшүүлж байна.

7. Сургалт болон хүний нөөцийн асуудлыг тусад нь авч үзэх шаардлагатай. ХХЕГ, Гааль, ГИАХЭГ-ын сургалт зохих хэмжээнд явагдаж байгаа бол бусад агентлагт сургалтыг сайжруулах шаардлагатай байна. Түүнчлэн ажлын байран дээрх сургалтыг сайжруулах, албажуулах нь зүйтэй гэж үзэж байна.

8. Хилийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцохыг хүсэхгүй, мэдээллийг цаг алдалгүй солилцох нэгдсэн тогтолцоо бүрдээгүй, аливаа үүссэн нөхцөл байдалтай холбогдон мэдээлэл солилцох тохиолдлын явдал гардаг хэдий ч шаардлага хангахгүй байна. Мөн

ХХЕГ-т эрсдэлийн дүн шинжилгээг огт хийхгүй байхад Гааль, ГИАХЭГ-т эрсдэлийн менежментийн системийг боловсруулан өдөр тутмын ажиллагаандаа ашиглаж байна. Иймд улсын болон агентлагуудын түвшинд мэдээлэл солилцох зохих механизм бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

9. Үнэлгээний баг нь техник төхөөрөмж болон дэд бүтцийн асуудлыг мөн судлав. Зарим газарт зорчигч, тээврийн хэрэгслийн шалгалтад хуучирсан, технологийн шаардлага хангахгүй техник төхөөрөмжийг ашиглаж байна.

Замын-Үүдийн боомтод хилийн цэргийнхэн тээврийн хэрэгслийн өдөр тутмын шалгалтад нэн хялбар (тухайлбал, тээврийн хэрэгслийн хөндий зайг төмөр шургуулж шалгах) боловч оновчтой арга хэрэгслийг ашиглаж байна. Дэд бүтцийн хувьд үнэлгээний баг зөвхөн Замын-Үүдийн хилийн боомттой танилцсан. Замын-Үүдийн хилийн боомтын шинэ байгууламж баригдаж байгаа ба бидний дүгнэлтээр энэхүү байгууламж нь багтаамж, талбайн хувьд хангалттай, гэвч үйл ажиллагааг бүрэн хангах төдийлөн боломжгүй, иймд хилийн байгууллагуудын үйл ажиллагаанд хүндрэл, бэрхшээл учруулж болзошгүй байна.

Хил хамгаалах байгууллага, хөгжлийн чиг хандлага

Хил хамгаалах байгууллага (ХХБ) гэсэн ойлголтыг олон улсын хэмжээнд хэрхэн тодорхойлдог эсэхийг зарим улсуудын жишээн дээр тодруулах, хилийн цагийн байдал хамгийн өрнөлттэй, хил дамнасан

зөрчил, гэмт хэрэг ихтэй, технологийн болон эдийн засгийн өндөр хөгжилтэй болон бусад орнуудын ХХБ-ын ойлголт, хөгжлийн хандлага өөр өөр байгаа бөгөөд тэдгээрийг харьцуулснаар олон улсын хэмжээнд ХХБ-ын хөгжил хааш чиглэж байгаа нь харагдах юм.

ХХБ-ын үндсэн үүрэг нь улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах хэдий ч улс орон бүрд тухайлан гүйцэтгэх үүрэг, харьяалал, статус, бүтэц, үйл ажиллагаа явуулах хэлбэр, бие бүрэлдэхүүн зэрэг нь өөрийн гэсэн онцлогтой байна.

Энэ бүхэн нь хамгийн гол нь тухайн улсын аюулгүй байдлын орчин, түүний дотор хилийн аюулгүй байдал, хилийн цагийн байдал, түүний талаар төрөөс нь ямар бодлого баримталж байгаагаас шууд хамааралтай гэсэн үг юм. Тухайлбал, Энэтхэг улс хөрш Пакистан, Бангладеш улстай харилцах харилцаа болон гарч буй зөрчлийн улмаас хамгийн цэрэгжүүлсэн, дэлхийд хамгийн олон хүнтэй Хилийн аюулгүй байдлын хүчнээр энэ хоёр улстай залгаа улсын хилээ хамгаалдаг бол бусад хил залгадаг улсуудын хилийг өөр өөр хилийн албадаар хамгаалуулдаг байна.

АНУ-ын хувьд 2001 оны есдүгээр сарын 11-ний террорист халдлагын дараагаар дотоодын аюулгүй байдлыг хангах хүрээнд хууль гаргаж Дотоодын аюулгүй байдлын яамыг 22 агентлагийг нэгтгэн 220 000 хүнтэйгээр байгуулсан. Үүнд багтгаж буй Хил, Гаалийн агентлагийн үндсэн чиг үүрэг нь дотоодын аюулгүй байдлыг хангахад оршиж байна. БНХАУ-ын хувьд хилийн

хамгаалалтыг ХАЧА-ийн цэргийн тойргууд хариуцан хамгаалж байгаа бол хилийн боомтоор шалган нэвтрүүлэх асуудлыг НАХЯ-ны Хилийн цэргийг удирдах газар, одоо Үндэсний цагаачлалын удирдах газар хариуцах болсон байна. ОХУ-ын хувьд гүйцэтгэх ажлын шугамаар хил хамгаалалтыг явуулах чиглэлтэй бөгөөд үүнийг ХАБА-ны Хилийн алба хариуцан гүйцэтгэж байна.

Өөрөөр хэлбэл, тухайн улсад тулгарч буй асуудалд төрийн бодлого боловсруулагчдын үзүүлж буй хариу үйлдэл, шийдвэр нь Хил хамгаалах байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийг нь тогтоож байна.

Хил Хамгаалах байгууллагын хилийн менежментийн хөгжлийн чиг хандлага

Олон улсын хэмжээнд Хил хамгаалах байгууллагуудын хөгжил нь тулгамдаж буй асуудал, хандлагад нийцсэн байх нь тодорхой болж байна. Энэ нь хил нэвтрэх зорчигчид, худалдаачид, хилийн албаны ажилтнууд, аюулгүй байдлын ажилтнуудын хамтын ажиллагаа байх ёстой.

Хил хамгаалах байгууллагуудын хувьд дараах гурван том хандлага хамгийн нөлөөтэй байх юм. Үүнд:

- үйлчилгээний чиг үүргээ ямагт харгалзах,
- бодит байдал, бодит мэдээлэлд үндэслэн үйл ажиллагаа явуулах,

- **цахим цогц нөхцөлд үйл ажиллагаагаа уялдуулах** зэрэг болно.

Энэ хандлагуудад дасан зохицож, ухаалгаар хариу үзүүлэн хөгжих Хил хамгаалах байгууллагууд хөгжил цэцэглэл, аюулгүй байдлын зорилтуудыг аль алиныг нь хангаж, үр дүнтэй, асуудал зөрчилгүй улсын хилийг бий болгох юм.

Дүгнэлт

Монгол Улсын хувьд хилийн менежмент гэдгийг үндсэндээ Төрөөс улсын хилээ удирдаж буй бүхий л үйл ажиллагаа гэдэг талаас нь харах нь зүйтэй болж байгаа юм.

Цаашид манай орны нөхцөлд нэг талаас эдийн засагт шаардлагагүй дарамт учруулахгүй, хүн хүчний зохистой нөөц шаардах, нөгөө талаас хилийн орон зайд улс орны эрх ашгийг хамгаалах чадамжтай Монгол Улсын хилийн онцлог байдалд нийцсэн хилийн менежментийн тогтолцоо байх талаар тоймтой судалгааны ажил хийх шаардлага бий. Энэ тогтолцоо Монгол Улсын хилийн физик, газарзүйн нөхцөл байдал, хил орчмын хүн ам, байгууллагуудын нягтрал, суурьшил, дэд бүтэц, эдийн засгийн боломж зэрэгтэй нягт уялдсан байх ёстой юм.

Хилийн менежментийг сайжруулах чиглэлд улс төрийн дэмжлэг, шийдэл зайлшгүй чухал бөгөөд аль нэг байгууллагын чиг үүрэгт дулдуйдсан биш, аюулгүй байдал, эдийн засгийн ач холбогдол, хууль ёсны байдал, хууль бус асуудлыг илрүүлэх чадавх зэрэг ашиг сонирхлуудыг тэнцвэртэй харсан, Засгийн газрын бодлогын хэмжээний

хандлагаар хандах зайлшгүй шаардлагатай.

Улсын хэмжээнд хилийн менежментийн цогцолбор стратегийг боловсруулах шаардлагатай байна

Хэдийгээр улс орны тусгаар тогтнолын баталгаа бодит улсын хил чухал байсаар байх хэдий ч технологийн өөрчлөлт, цахим ертөнцийн хөгжил зэрэг нь улсын хил гэдэг ойлголтыг ойрын ирээдүйд ихээхэн өөрчлөх нь тодорхой байна. Үүнд Хилийн менежмент, түүнийг хэрэгжүүлэгч хилийн албад дасан зохицож, хөгжиж, чиг үүрэг, алсын хараагаа тааруулах нь тодорхой болж байна.

Монгол Улсын хилийн менежментийн тогтолцооны үндсэн үзүүлэлтүүд болон хэрэгцээг тодорхойлох, хилийн менежментийг ирээдүйн хөгжил, шинэчлэлийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх зорилгоор 2013 онд Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүсэлтээр Австри Улсын Вена хот дахь Шилжилт хөдөлгөөний бодлого боловсруулах олон улсын төв (ШХББОУТ, ICMPD) хийсэн судалгаан дээр тулгуурласан **“Монгол Улсын хилийн менежментийн тайлан”**, түүнд тусгасан санал, зөвлөмжүүдийг анхааралтай судлан хэрэгжүүлэх нь зүйтэй.

Эх сурвалж:

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого

Хилийн тухай хууль

Дэлхийн хилийн аюулгүй байдлын их хурал. <https://world-border-congress.com/>

Дэлхийн худалдааны байгууллага. <https://www.wto.org/>

Дэлхийн гаалийн байгууллага. <https://www.wcoomd.org/>

Европын хил, эргийн харуулын агентлаг. FRONTEX. <https://www.frontex.europa.eu/>

Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага. INTERPOL. <https://www.interpol.int/en>

Цэнджав, Д. Дорж, Т. Хэвлэл мэдээллийн менежмент. -УБ., 2004.

Хилийн менежментийн үнэлгээний багийн Монголд ажилласан байдал. Үнэлгээний тайлан, 2013 оны 10, 11 дүгээр сар. ШХББОУТ.

Монгол Улсын Гаалийн ерөнхий газар. Худалдааг хөнгөвчлөх

нэр томьёоны Англи-Монгол тайлбар толь бичиг. УБ., 2020.он.

Tom Doyle. The Future of Border Management. in Gerard McLinden and others. Border Management Modernization.

The Future of Border Management: Maintaining security; facilitating prosperity. <https://www.pwc.com/gx/en/psrc/pdf/the-future-of-border-management.pdf>

Gerard McLinden and others. Border Management Modernization. <https://documents1.worldbank.org/curated/en/986291468192549495/pdf/588450PUB0Bord101public10BOX353816B.pdf>

Demetrios G.Papademetriou. The New Architecture for Border Management. <https://www.migrationpolicy.org/pubs/borderarchitecture.pdf>